



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо 2019.04.28

Дугаар 01/19

Улаанбаатар хот

“Баянгол зочид буудал” ХК-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит 26 -р хурлын протокол

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит 2019 оны 4 сарын 25 өдөр 15.00 цагаас Баянгол
рестораны зааланд хуралдав.*

Хурал даргалагчаар томилогдсон ТУЗ-ын гишүүн Б.Батжаргал хүндэтгэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй болсон тул ТУЗ-ын гишүүн З.Цэрэнчимэг хурлыг удирдан явуулах болсныг мэдээлэв.

Тооллогын комиссн дарга:

Хурлын ирц 81-иар бүрдсэнийг мэдээлээд, Тооллогын комиссын тогтоолыг уншиж сонсголоо.

Хурлын дарга З.Цэрэнчимэг:

Хурлын ирц 81-иар бүрдсэнийг мэдээлээд, хурлыг нээж, хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав. Энэ удаагийн хурлаар:

1.Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах

2.ТУЗ-ын 2019 оны төсвийг батлах гэсэн энэ хоёр асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ

3. Ноогдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, үндэслэлийг танилцуулах зэрэг асуудлууд багтаж байгаа.

Одоо эхний асуудлаар ТУЗ-ын дарга Б.Аюуш ТУЗ-ын дүгнэлтийг танилцуулна.

Б.Аюуш:

Өнгөрсөн 2018 оны Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн хураангуй, санхүүгийн тайлангийн талаар хөндлөнгийн аудитын дүгнэлтийг та бүхэнд тараасан байгаа. Үүнийг давтан ярихгүйгээр Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар буюу өөрөөр хэлбэл гүйцэтгэх удирдлагынхаа үйл ажиллагаанд ТУЗ ямар үнэлэлт дүгнэлт өгсөн бэ гэдгийг танилцуулах ёстой. Энэ талаар та бүхэнд танилцуулъя. Ард байгаа дэлгэцээр 2018 оны компанийн үндсэн үйл ажиллагааны тайлангийн гол гол үзүүлэлтүүд болон мэдээллүүдийг харуулж байгаа.

1. Санхүү эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн талаар

2018 онд төлөвлөгөөт зорилтоо ханган биелүүлсэн, ба урьд оныхоо гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээс ахисан байгаа. Сүүлийн жилүүдэд олон шинэ буудлууд, тэр дундаа олон улсын сүлжээ буудлууд ашиглалтанд орж зах зээлийн өрсөлдөөн улам нэмэгдэж байгаа хэдий ч бид өнгөрсөн оны төлөвлөгөөт зорилтоо ханган биелүүлж чадсан. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд сайн биелсэн гэж үзсэн, энэ нь орлогын

төлөвлөгөө өмнөх оны гүйцэтгэлээс 8%,-иар, төлөвлөснөөс 1%-иар, ашгийн хэмжээ 38%-иар өссөн, ашгийн өсөлтөд валютын ханшийн зөрөө бас нөлөөлсөн байгаа. Энэ өсөлт гарсан шалтгаан нь 2018 онд урлаг спортын хэд хэдэн томоохон арга хэмжээнүүдийг хүлээн авсан, мөн гэрээт болон жуулчны байгууллагуудтайгаа гэрээгээ сунган ажиллаж, тогтвортой хамтарч ажилладаг, байгууллага, харилцагчиддаа урамшуулал олгох гэх мэтээр гадаад дотоодын зочдыг татах тал дээр маркетингийн зөв бодлого барьж ажилласан. Хэдийгээр монголд ирж байгаа зочдоос манай буудал байрласан хувь бага зэрэг буурсан ч гэсэн өнгөрсөн оны гүйцэтгэлээс өссөн. Зардал төлөвлөснөөс тодорхой хэмжээгээр өссөн нь хэвийн өсөлт гэж үзсэн. Учир нь зарим бараа материалын үнийн өсөлт, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өссөн зэрэг бодит шалтгаанаас болжээ гэж дүгнэсэн. СЭЗ үзүүлэлтүүдийг тодорхойлдог кофциентүүдийг манай эдийн засагчид тооцож гаргасныг тараасан материалын 7-р хуудаснаас та бүхэн харж болно. Санхүү эдийн засгийн нөхцөл байдал хэвийн сайн байгаа. Манай компани нь хөрөнгийн биржийн “А” самбарт байршиж явдаг. Хувьцааны үнийн өсөлт, ногдол ашиг хоёроос хувьцаа эзэмшигчид өгөөж хүртэж байдаг. Хувьцааны ханшийн өсөлт гарч чадаагүй нь олон компаниуд хувьцаагаа шинээр гаргасан нь хөрөнгө оруулагчидын сонирхол тэр зүгт илүү чиглэсэн гэж таамаглаж байгаа. Ер нь манай ханш 30 орчим мянгад хэлбэлзэж байгаа. Харин топ 20 компаниудаас нэгж хувьцаанд хувиарласан ногдол ашгийн хувьд манайх хамгийн өндөр нь байгаа гэдгийг хэлмээр байна. Бид зах зээлд байр сууриа алдахгүй байхад өөрийндавуу талаа ашиглах ёстой, байршилын хувьд бидэнд давуу тал байгаа тул, буудлын нөхцөлөө сайжруулан өрсөлдөх боломжтой гэж үзсэн тулд өөрийн хөрөнгөөр 2– 3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт засвар хийж байгаа. Ирэх жилээс гадна фасадыг өөрчлөх, томоохон зал байгуулах ажлыг өөрийн хөрөнгөөр хийх боломжийн талаар судалгаа хийж байгаа, одоогоор эцэслэн шийдвэрлэгдээгүй, тул энэ оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хараахан тусгагдаагүй байгаа. Хэрвээ шийдвэр гарвал бид СЭЗ төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулж хэрэгжүүлэх болно. Давуу талаа ашиглан зах зээлд байр сууриа тогтвортой хадгалахын тулд өөрийн хөрөнгөөр хийх боломж, болон бусад олон талын судалгаа хийж байгаа. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны биелэлтхангалттай сайн биелүүлэхэд ТУЗ сайн ажилласан гэж үзсэн дүгнэсэн.

Санхүүгийн тайлангийн талаар зохих хууль тогтоомжуудын дагуу Хувьцаат компаниуд нь хөндлөнгийн аудитийн дүгнэлт хийлгэх ёстой байдаг ба ТУЗ-өөс “Сэрэлт дөл” аудитийн компанийг сонгож дүгнэлт гаргуулсан. Уг дүгнэлтэд **“Баянгол зочид буудал ХК- нь 2018 оны 12 сарын 31-ээрхсанхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг ОУ-ын стандартын дагуу үнэн зөв толилуулсан”** гэсэн дүгнэлт өгсөн, бид бас өөрсдийн хяналт, дүгнэлтээ хийж санхүүгийн үзүүлэлтүүд үнэн зөв гарсан гэж үзэж байгаа.

Та бүхний итгэлийг авч ажиллаж байгаа ТУЗ хэрхэн ажилласан талаар товч мэдээлэл өгье. Компанийн засаглалыг хэрэгжүүлэх тал дээр бид өөрсдийн ажилдаа дүгнэлт хийж, удирдлагын үр өгөөжийг сайжруулах тал руу чиглэж ажилласан, ноднингийн ээлжит хурлаас хойш нийт 14 удаа хуралдсан. Энэ хурлуудаар зайлшгүй

хийгддэг ажлуудаас гадна өнгөрсөн онд ISO90002015 чанарын удирдлагынстандартыг хэрэгжүүлэх ажлыг хийсэн, энэ нь компанийн үйл ажиллагаанд маш их дэвшил авч ирдэг стандарт юм. Одоо аудитораар шалгагдах шатандаа явж байгаа.Тэгээд гэрчилгээ авах ёстой.Энэ ажлын явцтай танилцсан, энэ нь маш өргөн хүрээтэй үйл ажиллагаа байдаг. Мөн албадын зорилт, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг сонсч, зөвлөмж өгч байгаа. Нийт 7 албатай. Одоогоор Маркетинг борлуулалтын алба, хүний нөөцийн ажлын явц байдал, төлөвлөгөөний хэрэгжилтэнд ямар асуудал байгаа талаар мэдээллийг сонсч үнэлэлт зөвлөмж өгсөн байгаа. ТУЗ-ээс өгсөн зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлын биелэлтийг нь эргэж сонсч ажилладаг. Ирэх жилдБаянгол гэсэн нэрийг хамгаалж чадах өөрсдийн брэнд үйлчилгээг буй болгох, үүндүйлчлүүлэгчдийн сэтгэлд нийцсэн найрсаг, тэдэнд сэтгэлээсээ үйлчилж чаддаг мэргэшсэн хамт олныг бүрдүүлэн ажиллах зорилт тавьж байгаа, 7нэгж бүр ямар зорилт тавин ажиллаж байгааг 12-р хуудаснаа уншиж болно.ТУЗ ээс гүйцэтгэх удирдлага сайн ажилласан санхүүгийн тайлан үнэн зөв толилуулагдсан гэсэн дүгнэлт хийсэн байгаа.

Дараагийн та бүхнээр хэлэлцэж батлуулах зүйл бол ТУЗ-ийн төсөв байгаа. Манай ТУЗ-ийн төсөв бусад компаниудыг бодвол харьцангуй даруухан, өнгөрсөн онд 35 сая төлөвлөснөөс 27.3 саяийн зарцуулалттай байсан. Энэ жил 32.1саяийг төлөвлөсөн байгаа. Энд ТУЗ ийн гишүүдийн цалин, хувьцаа эзэмшигчийн хурлын төсөв, хөрөнгийн биржийн шимтгэл багтдаг.

Ингээд хэлэлцэх 2 асуудалыг та бүхэнд танилцууллаа.

Дараагийн нэг танилцуулах асуудал бол зохих хуулийн дагуу мэдээлэх нэг асуудал байгаа нь ноогдол ашгийн талаарх мэдээлэл байгаа. Энэ жил ноогдол ашгийг нэгж хувьцаанд 355төгрөг байхаар тогтоосон. 9 сарын 1-ээс эхлэн компани дээрээс олгоно. Энэ нь компанийн мөнгөн гүйлгээтэй холбоотой гэдгийг ойлгоорой.Нэр, дансны дугаараа албан ёсоор үлдээвэл дансаар шилжүүлэх боломжтой.

Та бүхэндээ ТУЗ-ийн нэрийн өмнөөс талархлаа илэрхийлмээр байна. Олон хуралд сууж байхад манайх шиг олон хүн хуралдаа ирдэг, хуралдаа идэвхтэй оролцог байдал цөөн харагддаг. Жил бүхэн тайлангаа сонсохоор, мөн компани дээрээ юу болж байгааг мэдэхээр ирдэгт баярлалаа гэж хэлье.

3.Цэрэнчимэг: Ерөнхийдөө дэгийн дагуу хэлэлцэх асуудлууд яригдаж дууслаа.

Компаний болон Хөрөнгийн биржийн веб дээр бүх санхүүгийн тайлан, аудитийн тайлан тавигдсан байгаа. Та бүхэнд тараагдсан материалаас зохих мэдээллүүдийг авах боломжтой, мөн илүү дэлгэрэнгүй мэдээллийг өгөх зорилгоор дэлгэцээр үндсэн үйл ажиллагаа,онцлог үйл явдал, буудалд байрласан хүндэт зочид,хөрөнгө оруулалт, засвар, ажилчдын нийгмийн асуудал. сургалт, олон нийтийн арга хэмжээний талаар багцалж харуулж байгаа гэдгийг хэлье.

Одоо дэгийн дагуу асуулт, хариултын цаг эхэлсэн тул та бүхэн асуултаа асуугаад дараа нь саналаа хэлэх боломжтой.

Хувьцаа эзэмшигч Бэлэгдэмбэрэл: Би хүүхдийн нэр дээр хувьцаатай. Юуны өмнө төлөвлөгөөт зорилтоо ханган биелүүлсэн та бүхэнд талархлаа илэрхийлье. Надад хоёр асуулт байна.

– Балансийн тайлангаас харахад 15 тэрбумаас Их хэмжээний бэлэн мөнгө кассдаа 6 тэрбум байлгах, мөн банкинд бага хүүтэй мөнгө байршуулах ямар шаардлага байдаг вэ? Ямар хүүтэй вэ? Компаний эрх ашигт хэрхэн нийцдэг талаар хариулт авъя. - Мөн бусад авлага 14 тэрбум төгрөгийг хаанаас хэзээ авах, ямар зориулалтаар хүлээгдээд байгаа, авах ёстой вэ? – А буудлын хөрөнгө оруулалт хэзээ нөхөгдөх вэ? Энэ 3 асуултанд хариулж өгнө үү.

Б.Аюуш: СХАлбаны ахлах менежер хариулна.

Т.Бичигмаа:

-Эхний асуултанд хариулъя. Манай байгууллага 15 тэрбум мөнгөн хөрөнгөнөөс банкинд хүүтэй байлгадаг, хүү нь иргэдийн хадгаламжаас арай бага байдаг, ХХБ, ХААН банкиудтай гэрээ хийж 3 сараар сунгаад явдаг. Байгууллагын зардал, цалин, НДШ, цахилгаан, дулаан, ус гэх мэт 10 гаруй тэрбум төгрөг болдог. Иймд гадны эх үүсвэрээс хараат бус байхын тулд мөнгөн хөрөнгөө ингэж байршуулдаг.

-Хоёрдах асуултанд хариулъя. Дансны авлагад 13-р зууны хөшөөний авлага, засварын урьдчилгаа гэх мэт олон дүн байгаа, яг борлуулалтын цэвэр авлага 198 сая ба энэ нь 2018 оны үйл ажиллагааны орлого 6.8 тэрбумын 2.5% гэсэн үг. Энэ нь сайн үзүүлэлт байдаг. Хөндлөнгийн аудит ч гэсэн тэгж дүгнэсэн байсан.

3.Цэрэнчимэг:

- Гуравдахь асуултанд хариулъя. А буудлын 100 гаруй өрөөг иж бүрэн засаад тавилгыг нь сольж байгаа, мөн олон спортын тамирчид байрлах болсонтой холбогдон фитнес, сауныг өргөтгөн засварлах зайлшгүй хэрэгтэй болсон. Урьд нь А, Б буудал өөр тарифтай байсан, бид засвар хийгээд одоо тарифаа адилхан болгоод баталчихсан байгаа, бидний тооцоогоор 5 жилд зардлаа нөхнө гэсэн урьдчилсан тооцоо гаргасан. Засварын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулахдаа дотоодын компаниудыг дэмжих зорилгоор тендер зарлаад аль болох хамгийн бага үнэ өгсөн, найдвартай гэсэн компаниудыг сонгон ажиллуулдаг.

Б.Аюуш: Өгөөжийн хувьд зочдын тав тухтай байдлыг хангах, өрсөлдөөнт зах зээлд байр сууриа алдахгүй байх өөрсдийн тогтвортой үйл ажиллагааг хангахад засвар шинэчлэл зайлшгүй хийгддэг.

Заалнаас: Асуулт? Яагаад брокерийн пүүсээр хувьцаагаа тараахгүй байгаа юм бэ?

Б.Аюуш: Байгууллага дээрээсээ олгогдох нь зүйтэй. Оны эхэнд засвар хөрөнгө оруулалттай холбоотой ажил, дараа нь аялал жуулчлалын улирал эхэлдэгтэй холбогдуулан гол гол ажлууд хийгддэг. Үнэт цаасны төлбөр тооцооны төвд шилжүүлэхтэй холбогдсон хууль бус шийдвэрийг хэрэгжүүлэхгүй. Сул чөлөөтэй хөрөнгө

нь үндсэн компани дээрээ байрлаж үйл ажиллагаанд нь дэмжлэг болж явах ёстой гэж үздэг

Тэнгэр брокер: Сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөө илүү найдвартай эрсдэлгүй байлгах үүднээс бондын зах зээлд харьцангуй өндөр хүүтэй байрлуулах боломж байгааг судалж үзээрэй.

Т.Бичигмаа: Бидэнд олон газрууд санал тавьдаг. Энэ талаар бид бас сонирхож үзье.

Заалнаас асуулт: Өнгөрсөн оны ноогдол ашгаа аваагүй байгаа, хаанаас авах вэ?

З.Цэрэнчимэг: Өмнөх жилүүдийн ноогдол ашиг авахаар бол компани дээрээсээ хэзээ ч ирээд авч болох нээлттэй байгаа шүү

За өөр санал хүсэлт байна уу? Санал хүсэлт байхгүй бол тооллогын комисс ажилдаа орж, санал хураалтын ажлаа эхлүүлэе.

Саналын хуудсыг тусгай лац бүхий хайрцагт авч тооллогын комисс томилогдсон бүрэлдэхүүнээр ажиллан дүнгээ нэгтгэсэн болно.

Тооллогын комиссын дарга Д.Самданжамц тогтоолыг хуралд оролцогсдод уншиж танилцуулав.

З.Цэрэнчимэг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал амжилттай болж өнгөрснийг дурьдаад хурал хаасныг мэдэгдэв.

ХУРЛЫН ДАРГА

РЕДАКЦИЙН КОМИСС

З.ЦЭРЭНЧИМЭГ

Т.БИЧИГМАА

Р.ЦОГЗОЛМАА

